20

# ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 26 өдөр Дугаар А/12 Эрдэнэт

Спорт заалаар үйлчлүүлэх төлбөрт үйлчилгээний жагсаалт, үнийн тариф шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор "Спорт заалаар үйлчлүүлэх төлбөрт үйлчилгээний жагсаалт, үнийн тариф"-ыг хавсралтаар шинэчлэн тогтоож, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогын байгууллагын дансанд төвлөрүүлэхдээ цахим төлбөрийн системийг хэрэгжүүлэх, эрсдэлээс сэргийлж бэлэн мөнгийг аль болох ашиглахгүй /ажилчдын дансаар дамжуулахгүй/ байх талаар журам боловсруулж хэрэгжүүлэхийг нягтлан бодогч /Ж.Нямжаргал/, нярав-касс /Э.Баасанням/ нарт үүрэг болгосугай.

3. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний биелэлтийг сар бүр тайлагнаж, ил, тод байдлыг хангах ажиллахыг нягтлан бодогч /Ж.Нямжаргал/, нярав-касс /Э.Баасанням/ нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналт шалгалтын комиссын дарга /О.Заяа/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан даргын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР

Даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн
А/12 дугаар тушаалын хавсралт

# СПОРТ ЗААЛААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ, ҮНИЙН ТАРИФ

| № | Үйлчилгээний төрлийн нэр | | төлбөр | |
|---|---|---|---|---|
| 1 | Спортын төрлүүд /багш, дасгалжуулагч/ | Өсвөрийн шигшээ баг | 1 сар | 150,000 төгрөг |
| 2 | | нийтийн биеийн тамир, насанд хүрэгчдийн чийрэгжүүлэлт | Уурхайчин заал /1 цаг/ | 17,500 төгрөг |
| 3 | | | А заал /1 цаг/ | 12,500 төгрөг |
| 4 | Шинээр хөгжиж буй спортын төрлүүд /софт волейбол, ханан хад, … г.м/ | | 1 сарын | 60,000 төгрөг |
| 5 | Гэрээт байгууллагын чийрэгжүүлэлт | | А заал /1 цаг/ | 25,000 төгрөг |
| 6 | | | Уурхайчин заал /1 цаг/ | 35,000 төгрөг |
| 7 | Заалны подвал /0 давхар/ | | 1 сар | 100,000 төгрөг |
| 8 | Чөлөөт тоглолт | | А заал /1 цаг/ | 25,000 төгрөг<br>Том хүн-2000 төгрөг<br>Хүүхэд-1000 төгрөг |
| 9 | | | Уурхайчин заал /1 цаг/ | 35,000 төгрөг<br>Том хүн-2000 төгрөг<br>Хүүхэд-1000 төгрөг |
| 10 | | | | |
| 11 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настаны чийрэгжүүлэлт болон хөнгөн атлетик, өвлийн спортын төрлүүд | | 7 хоногт 2 цаг /өдөр/ | үнэ төлбөргүй |
| 12 | Секц, дугуйлан | Спорт тоглоомууд /сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг/ | 1 сар | 150,000 төгрөг |
| 13 | | Ганцаарчилсан спорт /бадминтон, буудлага, … гэх мэт/ | 1 сар | 100,000 төгрөг |
| 14 | | Самбо, жудо, чөлөөт, үндэсний бөхийн төрлүүд | 1 сар | 60,000 төгрөг |

----оОо----